

РОМЫН СОРИЛТ

Протестантууд яагаад Ням гарагт мөргөлөө хийдэг вэ?

Ихэнх Христэд итгэгчид Ням гарагийг библийн зөвшөөрсөн мөргөлийн өдөр хэмээн үздэг. Ромын Католик сүм Христ итгэлийн мөргөлийг Библид бичигдсэн мөргөлийн өдрөөс(Бямба гарагаас) Ням гарагт шилжүүлж, Библийг өөрчилсөн гэх шүүмжлэл нь шударга бус явдал хэмээн үздэг бөгөөд тэд католик шашинтнуудын эрх мэдлийг үгүйсгэж байгааг эсэргүүцдэг аж. Хэрэв протестантизм нь зөвхөн Библи дээр тулгуурлана гэвэл Бямба гарагт мөргөлөө хийх ёстой гэжээ.

Хэдэн жилийн өмнө “*Catholic Mirror*” (*Католик толин тусгал*) сэтгүүл дээр протестант сүмүүдийн Ням гарагт мөргөл хийх эрхийн талаар хэлэлцсэн цуврал нийтлэл гаргажээ. Христэд итгэгчид Католик Сүмийн мөргөлийн өдрийг хүлээн зөвшөөрөхгүй бол Бямба гарагт мөргөл хийх ёстойг нийтлэлд онцлон тэмдэглэжээ. Энэхүү нийтлэл бол уг сэтгүүл дээрх нийтлэлийг дахин хэвлэсэн хэвлэл юм.

1893 оны 2-р сарын 24-нд Долоо дахь өдрийн Адвентист сүмийн Ерөнхий Чуулганы хурал АНУ -ын дээд шүүхийн шийдвэр дээр үндэслэн АНУ-ын засгийн газар, ард түмэнд хандсан тодорхой тогтоолуудыг баталжээ. Үүнд шашин шүтлэг, түүний зарчим, мөн бүхий л үр дагаврын талаарх маргааныг Конгрессын үйл ажиллагаанаас хуульчлах тогтоолуудыг тус тус батлан АНУ-ыг Христийн шашинтан орон хэмээн зарласан юм. 1893 оны 3-р сард Олон улсын шашны эрх чөлөөний холбоо эдгээр тогтоолыг “*Давж заалдах болон дахин сануулах*” нэртэй товхимолд хэвлэв. Мэрилэнд мужийн Балтимор дахь “*Catholic Mirror*”-ын (*Католик толин тусгал*) редакторууд энэхүү товхимлоос нэгийг хүлээн авсны дараа 1893 оны 9-р сарын 2, 16, 23-ны өдрүүдэд сонинуудад нийтлэгдсэн дөрвөн нийтлэлийг нийтэлжээ. “*Catholic Mirror*” (*Католик толин тусгал*) нь АНУ-ын Кардинал Гиббонс ба Папын албан ёсны байгууллага байв. Тиймээс эдгээр бичээсүүдийг Кардинал өөрөө бичээгүй, харин Папын талын илэрхийлэмжийг албан ёсны зөвшөөрөлтэйгээр гаргаж ирсэн бөгөөд Пап лам протестантизмд нээлттэй уриалга гаргасан юм. Түүнчлэн үүнд протестантууд яагаад ням гарагт мөргөлөө хийдэг, мөн хэрхэн мөргөл үйлдэх талаар Ватиканд тайлбарлахыг хүссэн Пап ламын хүсэлтийг багтаасан юм.

Энэхүү редакцийн товч хэвлэлийн (25-р хуудаснаас эхэлж, 27-р хуудсанд төгсгөх дөрвөлжин хаалтанд оруулсан редакторын тэмдэглэл, мөн хоёр хавсралтан дахь тайлбараас бусад), хоёрдугаар хуудасны гарчгийг орууллаа.

Христ итгэлийн мөргөлийн өдөр

Ариун Сүнсний Холбоо ба Католик Сүмийн Жинхэнэ Үр удам.

Протестантуудын талаас гаргасан нэхэмжлэл нь үндэслэлгүй, бие биетэйгээ зөрчилдөөнтэй, өөрсдийгөө сүйрүүлэх талтайг нотлох нь -

(1893 оны 9-р сарын 2-ны “Catholic Mirror” (Католик толин тусгал)-оос)

Олон улсын шашны эрх чөлөөний холбооноос гаргасан “Давж заалдах болон дахин сануулах” нэртэй хорин нэгэн хуудастай товхимлыг хүлээн авснаар өнгөрсөн долоо хоногт бидний анхаарлыг дээрх сэдэв рүү хандуулсан юм. Долоо дахь өдрийн Адвентист сүмийн Ерөнхий Чуулганы хурлаас (1893 оны 2-р сарын 24) баталсан тогтоолуудыг тусгасан болно. Энэхүү тогтоолуудад АНУ-ын Конгресс болон Дээд шүүхийн үйл ажиллагааг Ням гарагт болгож “Дэлхийн яармаг”-аар дуусгасан нь хүмүүсийн эрхийг зөрчсөн үйлдэл хэмээн эрс шүүмжилж, буруушаажээ.

Библид эхний өдрийг долоо дахь өдөр рүү өөрчлөх өөрчлөлтийн талаар ямар ч баталгаа байдаггүй хэмээн үздэг хүмүүс бол Адвентистууд бөгөөд Библийг зааварлагчаа болгосон Христэд итгэгчдийн цорын ганц байгууллага юм. Тиймээс тэдний нэр нь "Долоо дахь өдрийн Адвентист сүм" юм. Израилийн хөвгүүдийн хэдэн мянган жилийн турш өнөөг хүртэл үг дуугүй дагаж мөрдөж ирсэн, Хуучин болон Шинэ гэрээн дээр удаа дараа давтан хэлсэн, Бурханы Өөрөө өгсөн тушаалын дагуу зөвхөн Бямба гарагт Бурханд мөргөл өргөх явдал нь тэдний үндсэн зарчим юм.

Дэлхийн өнцөг булан бүрт байгаа Адвентистуудаас бусад Протестантууд XVI зуунд гарч ирснээсээ хойш Библийг үнэ цэнэтэй, цорын ганц алдаагүй зааварлагч гэж үзсэн хэдий ч Иудейчүүдийн Бурханы мөргөлийн өдөр гэж нэрлэгддэг тэр өдрийг эсэргүүцсэн явдал нь Адвентистуудын үзэлтэй мөн зөрчилддөг юм. Тэдний мөргөл хийдэг өдөр Библийн нэг ч хуудсанд дурдагдаагүй байдаг.

Ямар протестант пастор ням гараг бүр мөргөлийн жинхэнэ өдрийн талаарх зөрчилдөөнийг дурдахгүйгээр өнгөрдөг бол? “Дэлхийн яармаг”-ийг ням гарагт үйл ажиллагаагаа хийхийг эсэргүүцсэн протестант удирдагчдын маргааныг улс орон даяар хэн мартаж чадах билээ? ЭЗЭНий өдрийг гутаан, доромжлолоос аврахын тулд хэдэн сая хүний зурсан гарын үсэгтэй мянга мянган өргөдлүүд үү? Мэдээжийн хэрэг, энэхүү амьд эсэргүүцлийг баталгаатай хүчтэйгээр, үндэслэлгүйгээр ийм өргөн цар хүрээтэй, нийтлэг шинжтэй байлгах боломжгүй байсан билээ.

Янз бүрийн урсгалын протестантизмуудад зориулсан “Дэлхийн яармаг”-ийн нийтлэлийн үзэсгэлэн дэх хэсгүүдийн хувиарлалтын үеэр ням гарагт хийгдэх мөргөлд саад болж болохгүй гэсэн Дээд шүүхийн шийдвэрийг тэд сонссон даруйдаа Пресбетириан ахан дүүс уур хилэнгээ ёс суртахуунтайгаар хүчтэй илэрхийлснийг хэн мартаж чадах билээ? Сонингийн газруудын бидэнд мэдээлсний дагуу тэд өөрт олгогдсон боломж болон нийтлэлээ

үзүүлэх хэсгүүдээ ашиглахаас эрс татгалзан, өөрсдийн зарчмыг чандлан сахиж буйгаа, мөн нийтлэлээ эргүүлэн авах эрхээ шаардсаар, мөргөлийн өдрийг өөрчилж буй үйл ажиллагаануудтай цаашид холбоогоо тасалж байгаагаа бидэнд мэдэгдэв.

Мэдээжийн хэрэг, манай Калвинистийнхан мөргөлийн өдөр мөргөлөө хийж байхдаа амьгүй мэт дүр эсгэн бусад бүх урсгалуудын өрөвдөх сэтгэлийг хүртэх ёстой байсан нь дамжиггүй. Тиймээс тэд монополь эрхээ түгээж чадаагүй протестантуудын өөрчлөгдөөгүй шашны зарчмуудаа баримталсныхаа төлөө фарисайчуудын бахархал, тууштай зан чанарыг үл тоомсорлож, өөрсдийнхөө өгөөмөр, атаархмаар зан чанарыг үл тоон "дэлхий ертөнц, тэнгэр элчүүд, хүмүүсийн үзмэр нь" болжээ.

Энэхүү нийтлэлийг няцаах болсон бидний зорилго бол эдгээр бүх чухал асуултуудын талаар тодруулга өгөх бөгөөд хэрэв мөргөлийн жинхэнэ өдрийн талаарх асуудлыг Протестантуудаас аваад хаявал бусад урсгалууд замаа алдсан мэт болж, номлогчид өөрсдийн "Чешир бяслаг"-аасаа татгалзахад хүрэх болно. Ингэснээр уншигчид бүх талын ойлголтыг авч, улмаар тодорхой итгэл үнэмшилд хүрэх болно.

Христэд итгэгчдийн долоо хоногийн эхний өдөр Бурханд мөргөх зан үйл нь ёс суртахууны хувьд энэхүү асуудал дээр нэгдмэл байдаг.

Дэлхий даяар тархан суурьшсан Израильчууд долоо хоногийн сүүлчийн өдрийг (Бямба гараг) Бурханд мөргөл үйлдэх зүй ёсны өдөр гэж үздэг. Тухайлбал, Долоо дахь өдрийн Адвентистчууд (Христэд итгэгчдийн цөөн тооны гэгшүүдтэй урсгал) мөн тэр өдрийг сонгосон.

Израильчууд болон Адвентистууд Бямба гарагийг чанд сахиж, Библи дэх Бурханы тушаалуудыг дагаж мөрдөхийг шаарддаг.

Израиль хүн зөвхөн Хуучин гэрээг эрхэмлэн хүндэтгэдэг бол Христэд итгэгч Адвентист нь шинэ гэрээг хуучин гэрээний хамт нэгэн түвшинд авч үзэн зөгнөлийн сүнсээр бичигдсэн хэмээн хүлээн зөвшөөрдөг. Тэд өөрсдийн зааварлагч гэгддэг Библиэс Аврагчийн дэлхий дээрх амьдралынхаа цаг үед Бямба гарагаас өөр өдөр мөргөл үйлддэггүй байсныг, мөн Библийн хоёр хэсэг нь өөр хоорондоо нийцэн холбогддог буюу сайн мэдээнүүдийн номууд үүний нотолгоо болж өгдөгийг судлан олсон юм. Үйлс, Ефес болон Илчлэлт номуудын хуудсуудаас бямба гарагт мөргөл үйлдэхийг болиулсан ул мөр огт байдаггүй юм.

Адвентистчууд Израильчуудын адил хуучин гэрээнд итгэдэг бөгөөд үүнийгээ Христэд итгэгчдийн эрин зууны үед байсан Аврагч болон түүний элч нарын амьдрал, зан үйлээр бүрэн нотлогддог Библийн бичээс болох Шинэ гэрээгээр баталгаажуулдаг.

Долоо дахь өдрийн Адвентистууд дэлхийн протестант хүн амын цөөн хувийг бүрдүүлдэг нь зүгээр ч нэг тоотой холбоотой асуудал биш бөгөөд харин үнэн зөв баримттай, бодитой, шударга ёстойгоор, эрх зүйн хувьд нэг талыг барьсан алагчлалгүйгээр энэ урсгалыг буруушаах нь хориотой байх явдлын талаар юм.

Ихэнх Протестантуудын хувьд анхнаасаа XVI зуунд Католик сүмтэй бүрэн нийцэж, Бямба гарагт биш, харин ням гарагт "ариун" мөргөлийг хийсээр ирсэн. Хэрэв Израиль ба Адвентистуудын 300 гаруй жилийн туршид оршсон нэгдмэл байдал, зан үйлээ шүүмжлэгч болон няцаагчдын хувьд ямар ч нөхцөлд хүлээн зөвшөөрөгдсөн цорын ганц үнэн болох Библийн нотолгооны дагуу уг асуудлыг хэлэлцэх аваас энэ нь протестантизмийг улам бэхжүүлэхэд туслах болно. Гэвч нөгөө талаас, Ням гарагийг чанд сахихын тулд маш их хичээнгүйлэн тэмцэж буй энэ олон тооны протестантуудыг энэхүү маргааныг эцэс болгох, хоёр талын аль аль нь бүрэн дүүрэн хүлээн зөвшөөрдөг ганц үнэн болох Библиэс маргаангүй нотолгоог гаргаж ир гэвэл тэд гурван зуу гаруй жилийн туршид сахьсан итгэл бишрэлээсээ урван, Библийн бүх сургаалиудыг үгүйсгэн, урвагч сүмийн сургамжинд итгэсэн мэт дүр эсгэн, гаж буруу зан үйл хийснээ хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй байдалд орох юм. Мөн Бурхан Өөрийн үнэнч зарц нартаа өгсөн бичээс дээрх өршөөж боломгүй, хамгийн ойлгомжтой, тодорхой зарлигуудын нэг болох “Амралтын өдрийг ариун байлгахын тулд санаагтун” гэсэн сургаалыг дээрх нөхцөл байдлыг батлахын тулд дахин нэг удаа бичлээ.

Израильчууд болон Долоо дахь өдрийн Адвентистуудын итгэж биширдэг Эхлэлээс Илчлэлт хүртэлх Библийн бичээсүүдийг биш тэрхүү урвагч сүмийг дагахыг илүүд үздэг өнөөгийн ямар ч протестант сүм дээрх тушаалыг биелүүлээгүй л байна. Хоёр тал хоёулаа “алдаа мадаггүй” үнэн гэгддэг Библид л хандан, Бямба эсвэл Ням гараг бол Бурханы тушаасан өдөр мөн эсэхийг Библиэр шийдэх хэрэгтэй. Бид хоёр талын мэтгэлзэж буй асуудлын үр дүнгийн талаар ярилцах хэрэгтэй. Тухайлбал бидний аль нэгний буруу байж энэ чухал асуудлаар буруу байр суурьтай тал нь “үүрдийн гэрээ”-гээ зөрчсөн хэмээн Бурханы Өөрөө хүртээх аймшигт шийтгэл амсах болно. Энэхүү онцгой чухал сэдвийн талаар хэлэлцэх нь жирийн хүний чадвараас хэтрэх зүйл биш бөгөөд, тусгай судалгаа шаарддаггүй. Үүнийг хэд хэдэн энгийн асуултаар шийдэж болно. Үүнд:

1. Библи долоо хоногийн аль өдөр мөргөл хийхийг заадаг вэ?
2. Шинэ гэрээ нь анхны тушаалыг дагаж мөрдсөн үү эсвэл түүнийг өөрчлөн шинэчилсэн үү?
3. XVI зуунаас хойших протестантууд Бурханы тушаалыг дуулгавартай даган мөрдөж, цорын ганц үнэн болох Библийнхээ тушаасан ариун өдрийг сахин мөргөл үйлддэг байсан уу? Хэрэв үгүй бол яагаад?

Дээрх гурван асуултын хувьд бид өөрсдийнхөө үнэнийг баталж, алдаатай буруу зүйлсийг арилгах ухаалаг хариулт өгөхөө амлаж байна.

(1893 оны 9 -р сарын 9-ний “Catholic Mirror” (Католик толин тусгал))

“Хэт туйлширсан итгэл үнэмшил нь нэгэнт л худал хуурмагтай бат бэх холбоо тогтоосон бол эцсээ хүртэл түүнтэйгээ зууралдсаар байдаг.” **Мөөр**

Өнгөрсөн дугаарт өгсөн амлалтынхаа дагуу бид Библийн итгэлийн дүрмийн хамгийн тод алдаа болон хүлээн зөвшөөрөгдөх боломжгүй маргааны үнэн нүүр царайг харуулах болно.

Тиймээс биднийг буруугаар ойлгохгүйн тулд эхлээд нэг зүйлийг мэдэх хэрэгтэй. Бидний Протестантизмын талаарх үзэл бол "алдаа мадаггүй Библи"-с өөр итгэлийн ямар ч дүрэм журмыг, ямар ч үзэл баримтлалыг хүлээн зөвшөөрдөггүй явдал юм. Католикчууд итгэл бишрэлтэй холбоотой асуудлын шийдвэрээ сүмийнхнээсээ далд байлган, нуун дарагдуулдаг бол протестантууд Библиэс өөр үнэнийг хүлээн зөвшөөрдөггүй. Тэдний бүх сүнслэг байдал нь Түүний сургаалаас үүдэлтэй юм. Энэ бол тэдэнд урам зориг өгдөг цорын ганц үнэн болох Библи хэмээх зааварлагчаар дамжуулан өөрсдөд нь хандаж буй Бурханы дуу хоолой юм гэдэгт итгэдэг. Энэ нь тэдний шашин шүтлэг, итгэл үнэмшил, зан үйлийг бэлэгддэг. Чиллингвортын хэлснээр "Библи, Библи бүхэлдээ, Бурханы ном" гэдэг шиг Библиэс өөр зүйлс нь протестант итгэл бишрэл биш бөгөөд "Бидний авралын дүрэм", "Бидний Христийн шашны итгэл үнэмшил", "Хүн төрөлхтний тэмцэлд зориулагдсан Бурханы сурах бичиг" гэх мэт хэллэгүүд нь Библи гэгдэх нэг утга санааны олон янзаар илэрхийлэх хэлбэрүүд юм. Тиймээс, Библи нь дангаараа протестантууд, Христэд итгэл бишрэлийн зааварлагч гэдэг нь маргаангүй баримт юм. Энэ баримтыг харгалзан үзвэл бид сүүлийн дугаартаа оруулсан асуултынхаа хариултыг хэлэлцэхэд хангалттай юм.

Нэг талаас Долоо дахь өдрийн Адвентистуудын протестант сургаал, зан үйл, нөгөө талаас Бурханд мөргөхийн тулд долоо хоногийн өөр өдөр мөргөл хийдэг Иудейчүүдийн сургаал, зан үйлийн хооронд маргаангүй зөрчил байгааг хүлээн зөвшөөрч, 2 талын аль алинд нь байдаг нийтлэг зүйл, өөрөөр хэлбэл бидний дундах цорын ганц баталгаат үнэн болох Библи гэгдэх зааварлагчийн гэрчлэлийг үргэлжлүүлэх болно. Эхлэл 2:2 дээр “Долоо дахь өдөр болоход Бурхан Өөрийн хийж бүтээсэн ажлаа дуусгаж, хийж бүтээсэн ажил нь дууссан учир долоо дахь өдөртөө Тэрээр амарчээ” гэдэг. Уг бичээс дээр мөргөлийн өдрийн талаарх анхны илэрхийлэл буюу хэллэг гардаг. Үүний дараагийн эшлэл нь Египетээс гарсан нь 20-р бүлэгт байдаг бөгөөд “Бурхан долоо дахь өдөр амрахыг тушаасан бөгөөд учир нь тэр өдөр Тэр бүтээлийн ажлаасаа амарсан юм.” Тийм ч учраас Библид Түүний юу хүссэнийг өгүүлсэн байдаг. “Тиймээс Их ЭЗЭН долоо дахь өдрийг ивээн ерөөж, ариун болгосон билээ.” Дахин хэлэхэд бид 31-р бүлгийн 15-р эшлэл дээр гардаг шиг “Зургаан өдрийн туршид ажил хийж болно. Харин долоо дахь өдөр нь ЭЗЭНд ариун болоод бүтэн амрах амралтын өдөр билээ.” 16-р эшлэл дээр “Тиймээс Израилийн хөвгүүд амралтын өдрийг “**үеийн үед мөнхийн гэрээ**” болгон тэмдэглэхийн тулд амралтын өдрийг сахигтун” гэсэн байдаг.

Хуучин Гэрээн дээр Амралтын өдрийн талаар зуун хорин зургаан удаа дурдсан байдаг бөгөөд эдгээр бүх бичээсүүд нь долоо дахь өдрийг сахихыг тушаасан Бурханы хүслийг илэрхийлдэг. Учир нь Бурхан Өөрөө анх энэ өдрийг сахисан бөгөөд биднийг заавал энэ өдөр мөргөлөө үйлдэхийг шаардан **"мөнхийн гэрээг"** хийсэн юм. Түүнчлэн, Израильчууд Бямба гарагийг МЭӨ2514 - МЭ1893 он хүртэл 3383 жилийн турш хууль өгөхөөс эхлэн сахиж ирсэн байдаг. Өнөөгийн бидний нүдээр Израильчуудын энэхүү жэшээнээс Бямба гарагийг Хүндэтгэлийн өдөр эсвэл долоо дахь өдөр гэдэгт эргэлзэх хэн нэгэн байна гэдэг муу зүйл юм. Христэд итгэлээс 1490 жилийн өмнө амьдарч байсан Бурханы сонгогдсон хүмүүс, Хуучин гэрээг сахигчид болон өнөөг хүртэлх монотеист итгэлийн амьд төлөөлөгч нар Бямба гараг бүр "Эзэнд ариусгагдсан" онцгой өдрийг зөв сахихын тулд уг уламжлалаа хадгалсаар ирсэн нь 1893 онд улам бүр өргөжин тэлж, Христэд итгэлийг бүхэлд нь хамарсан юм. Бид энэ тал дээр бүрэн дүүрэн ойлгомжтой байх шаардлагатай хэмээн үзэж, улам илүү дэлгэрэнгүй бичих

болно. Хуучин гэрээн дээрх бичээсийн дагуу 3383 жилийн турш Бурханы сонгогдсон ард түмний сахиж ирсэн уламжлалт, мөргөлийн өдрийн талаар: Бурхан Өөрөө тэр өдрийг ариун гэж үзэн, зарлигийг зөрчсөн хүн үхэх болно гэж хэлсэн юм. “Юу гэвэл энэ нь та нарт ариун юм. Үүнийг бузарласан хүн бүр үхэх ёстой. Энэ өдөрт ямар нэг ажил хийдэг хэн боловч өөрийн ард түмний дундаас таслагдана”(Египетээс гарсан нь 31:14).

Хуучин гэрээний хуулиудад 126 буюу үүнээс ч олон удаа дурдагдсан уг зарлигуудыг зөрчсөн бүх хүмүүст анхааруулсан дээрх бичвэрийн үгс болох Бурханы үгнээс илүү хүнд шийтгэлийг бид төсөөлөх боломжгүй юм. Библийн Хуучин гэрээн дэх арван хууль нь Христэд итгэгчдийн болон Ням гарагийн цуглаанууд дахь хүүхдүүдийн ой санамжинд хурдан үлддэг ч, Ариун өдрийн тухай хууль нь бусад бүх хуулиудаас илүү хүчтэйгээр тэдний зүрх сэтгэлд тодоос тодоор үлддэг юм.

Бичээс дэх ариун өдрийн тухай Бурханы хүслийг бүрэн дүүрнээр биелүүлэхийн тулд Түүний сонгосон хүмүүс олон мянган жилийн турш уг өдөр амарч байсан бөгөөд энэ өдрийг бидэнд бататгаж өгсөн юм. Бурханд мөргөл үйлдэх өдөр хэзээ, хаана өөрчлөгдсөн талаарх асуулт руу бид аяндаа хөтлөгддөг. Учир нь энэхүү өдөр өөрчлөгдсөн нь дэлхий нийтэд илэрхий бөгөөд ийм ямар ч өөрчлөлт хийх тухай хуучин гэрээн дээр байддаггүй юм. Бараг XIX зууны турш үргэлжилсэн еврей хүмүүсийн зан үйлээс олж харж чадахгүй юм. Христэд итгэлийн эрин үеийн төлөөлөгчдийн бичээс болох Шинэ гэрээнээс хүртэл уг өөрчлөлтийн талаар Бурханы тушаалыг бид олж чадахгүй билээ.

XIX зууны багахан хугацааг хамарсан энэ үед нэмэлт Бурханы үг болох Шинэ гэрээн дээр Хуучин гэрээн дэх хуулийн бүрэн эрхийг хүчингүй болгосон эсэхийн талаар болон мөн Шинэ гэрээ нь хуучин гэрээн дээрх Бурханаар тогтоогдсон амралтын өдрийг орлуулах тухай зарлиг агуулж байгаа эсэхийг судалж байна. Бурханы эрх мэдэл дангаараа Бямба гарагийн гэрээг хүчингүй болгож чадах бөгөөд Бямба гарагаас өөр өдрийг "ариун" өдрөөр өөрчлөх нь Христэд итгэгчдийн ухамсарт байж болохгүй зүйл юм. Өөрөөр хэлбэл Бямба гараг нь Бурханы сахиулахыг тушаасан хуулийн дагуух өдөр юм. Христэд итгэгчдийн хүлээн зөвшөөрсөн цорын ганц үнэн зааварлагч Библийн хуучин гэрээн дээр уг өөрчлөлтийн талаар огтхон ч бичигдээгүй бөгөөд Бямба гарагийг Библи "Ариун өдөр" гэж үздэг. Тиймд шинэ үеийнхэн буюу Христэд итгэгчдийн эхэн үеийнхнээс л хойш тэд Шинэ гэрээн дээр бямба гарагийг цуцалж, Ням гарагаар орлуулах шинэ журмын талаар онцлон тэмдэглэсэн хэмээн үзэх болсон нь ажиглагдсан юм.

Шинэ гэрээг эхнээс дуустал нь судалж үзэхэд Хүндэтгэлийн өдрийн талаар жаран нэгэн удаа дурдсан байдаг. Түүнчлэн Аврагч синагогт хичээл зааж, гайхамшгуудыг үйлдэхдээ Амралтын өдрийг(Бямба гараг) үргэлж сонгодог байсныг бид олж харж болно. Сайн мэдээний дөрвөн номонд л гэхэд Хүндэтгэлийн өдрийг (Бямба гараг) тавин нэгэн удаа дурдсан байдаг.

Нэгэн удаа Аврагч Өөрийгөө Матай, Лук нарын дурдсанчлан "Амралтын өдрийн Эзэн" гэж нэрлэдэг бөгөөд амьдралынхаа бүхий л хугацааны туршид Тэрээр тэр өдрийг (Бямба гараг) заншил болгон сахисаар ирсэн билээ. Мөн Тэр энэ өдрийг өөрчлөх хүсэлтэй байгаагаа хэзээ ч хэлж байгаагүй. Түүний дагалдагч нар болон дотны хүмүүс хүртэл түүнийг нас барсны дараа энэ өдрийг чанд сахиж байсан гайхалтай жэшээ бидэнд бий бөгөөд Лук 23:56 дээр: “Тэд буцаж ирээд, анхилуун үнэртэн болон үнэрт тос бэлджээ. Амралтын өдөр тэд тушаал ёсоор

амрав” гэжээ. “Амралтын өдөр ойртож байсан тул баасан гарагийн орой бэлдсэн анхилуун үнэртнээ долоо хоногийн эхний өдөр, өглөө эрт авчирч ирэв”(23:54, 24:1). Түүнийг нас барсны дараагаар Аврагчийн дотны хүмүүсийн хийсэн энэхүү үйлдэл нь тэднийг бямба гарагийг "ариун" байлгаж сахисныг, мөн ням гарагийг долоо хоногийн эхний, энгийн л нэг өдөр гэж үздэг байсныг харж болох юм. Тиймээс дагалдагч нар болон эмэгтэйчүүд Христийн үхэх өдрийг хүртэл Бямба гарагаас өөр Амралтын өдрийг мэддэггүй байсан гэдгээс илүү тодорхой зүйл байна уу?

Бидэнд сайн мэдээг тунхаглагч Лукийн бичсэн Үйлс номноос Христээс хойшхи дараагийн гучин жилд энэхүү сонирхолтой асуудлын талаар бичигдсэн эсэхийг судлах үлдэж байгаа юм. Мэдээжийн хэрэг, бид элч нарын зан үйлээс энэ өөрчлөлтийг хийсэн эсэхийн талаар ул мөрийн баримтыг олж мэдэх боломжтой юм.

Гэхдээ харамсалтай нь, Үйлс номонд Амралтын өдрийн талаар есөн удаа дурддаг боловч энэ нь Бямба гараг(хуучин амралтын өдөр) гэдгээр л гардаг юм. Хэрэв манай уншигчид нотлох баримтыг хүсч байвал бид дээрх тохиолдол бүрт бүлэг, эшлэлийг үлдээе. Үйлс 13:14, 27, 42, 44. Мөн дахин нэг удаа, Үйлс 15:21; Үйлс 16:13; Үйлс 17:2; Үйлс 18:4. “Тэгээд тэр (Паул) амралтын өдөр бүр синагогт ярьж, иудейчүүд, грекчүүдийг ятгаж байв.”

Ийнхүү Эхлэлээс Илчлэлт хүртэлх Амралтын өдөр нь Бямба гарагийг л заасаар байдаг. Шинэ гэрээнд Аврагч болон түүний дагалдагчид Амралтын өдрийн өөрчлөлтөнд өчүүхэн төдий ч нөлөөлөн, хөндлөнгөөс оролцоогүй болохыг бид олж харж болно. Харин ч эсрэгээрээ Тэрээр амьд байхдаа, мөн Түүний дагалдагч нар түүнийг дээшлэлэргөгдсөнөөс хойшхи гучин жилийн турш Ариун өдрийг итгэмжтэйгээр сахин өнгөрөөдөг байсныг Үйлс ном бидэнд хангалттай гэрчлэн харуулдаг.

Иймд бид доорх дүгнэлтийг хийх нь зайлшгүй юм. Библийн үгсээр удирдуулан чиглүүлэгддэг хүмүүс болох Израильчууд болон Долоо дахь өдрийн Адвентистууд уг асуулын тал дээр баталгаа нотолгоотой байдаг бол харин зарим протестантууд Бямба гарагийг Ням гарагаар сольсон шалтгаанаа хамгаалах бичээсийн үгсийг огт хэлдэггүй юм.

[1893 оны 9-р сарын 16-ны “Catholic Mirror” (Католик толин тусгал)]

"Анхнаасаа алуурчин", "худал хуурмагийн эцэг" байсан Сатан, хамгийн анхны эх болох Еваг мэхэлж, "Та нар сайн мууг мэддэг бурхад шиг байх болно" хэмээн хуурсан билээ. Түүний энэ үйлдэл нь хожим сая сая хүн төрөлхтнийг уруу татахад хүргэсэн бөгөөд амжилттайгаар гүйцэтгэж чадсан анхных нь хууран мэхлэлт байсан юм. Евагийн үр удам эх шигээ хэтэрхий оройтон суралцсан юм. Бурханд үнэнч байлгахгүйн тулд Түүний сул дорой хүүхдүүдийг уруу татсан нь Сатаны харанхуйн хаанчлалын төлөвлөгөөнөөс үл хамаарах зүйл биш юм.

Есүсийн загалмайн үйлсээс хойш гурван зуун жилийн турш сатан олон тооны сэтгэл ханамжгүй, амбицтай Христэд итгэгчдэд, тэдний зааварлагч болох Библийг орлох шинээр төрсөн зөнчид итгүүлэх, Бурханы Хүүгийн байгуулсан сүмийг орхисноор, "Шинэ эхлэл"-ийн гарааг амжилттай хийх сайхан ирээдүй хүлээж байгааг итгэл үнэмшилтэйгээр танилцуулсан байдаг.

Хорон санаат чөтгөрийн алсын хараа нь энэхүү ажиллагаанд гайхалтай үр дүн авчирсан ч эцэст нь түүний өөдрөгөөр тавьсан хүлээлт нь санасандаа хүрээгүй юм.

Гагцхүү зоригтой, овсгоотой ганц л хүн их аяныг зорьсон байхад л хангалттай байв. Сатаны хорон муу санааг удалгүй урвагч лам Лютер олж мэдсэн бөгөөд тэрээр өөрийн эзэнтэйгээ үүсгэсэн гүн харилцааг 1558 онд Меланчтоны удирдлаган дор Виттенбергт хэвлүүлсэн "Ширээний яриа" болон бусад бүтээлүүдээрээ хэлж, олон удаа гэрчилсэн юм. Лютер өөрөө Сатантай олон удаа ярилцсан тухайгаа гэрчилсэн байдаг. Едэн цэцэрлэгт могой өөрийн нөлөөллийг нэмэхийн тулд эрх мэдлээ маш үр дүнтэйгээр ашиглахыг эрмэлздэг байсан бол Лютерийн эрх мэдэл Христэд итгэлийн ертөнцөд том нөлөөг үзүүлсэн билээ.

*"Тэдэнд хэсүүчилж буй хүлэг онгоцны жолоочийг өг,
Тэр зоримог байсан бөгөөд заль мэхний чадварт суралцсан байв:
Түүний гар тэдний адал явдлын залуурыг төөрөгдүүлэн
Дайсны эрэг рүү хөтөлж, далайн түрлэг тэднийг ганхуулах болно.*

Чөтгөр хорон муу санаатнуудад санал болгосон төгсгөл нь Христийн сүм рүү дайрч, Христэд итгэлийг устгах явдал байв. Одоо бид түүний сонгосон зам хэр амжилттай явааг шүүн тунгаах ажилд анхаарлаа хандуулж байна. Өнөөг хүртэл тэр тэднийг худал хуурмагаар төөрөгдүүлж, өөр хооронд нь зөрчилдүүлж байгаа юм. Харин бид энэ худал хуурамч байдлын талаар шүүн тунгааж, үргэлжлүүлэн харцгаая.

Аврагч амьдралынхаа туршид Ариун өдрийг(Бямба гараг) сахих итгэмжит байдлаасаа нэг ч удаа гажиж байгаагүйг батлахын сацуу дөрвөн сайн мэдээний номын дагуу 51 удаа үүний тухай бичигдсэн байдаг бөгөөд тэрээр өөрийгөө “Ариун өдрийн Эзэн” хэмээн өргөмжилж, нэг удаа ч болов уг өдрийг өөр өдрөөр сольж, дагалдагч нар болон “ариун эмэгтэй”гээр(өөрийн ээж) сахиулах хүсэл эрмэлтээлтэй байгаагаа харуулаагүй юм. Түүний үхлийн дараа ч яг тэр өдрийн үдээс хойш түүний биеийг оршуулахын өмнө Лук номонд тодорхой бичигдсэний дагуу(Лук 24:1) ямар ч эргэлзээ төрүүлэх зүйл үлдээлгүйгээр амьдралынхаа турш Ариун өдрийг тууштай сахисан байдаг. Тэнгэрлэг Бурханы Хүүгийн үхлийн дараа ч гэсэн Түүний дагалдагч нар мөн адил 30 жилийн туршид Лук болон Үйлс номд бичигдсэний дагуу маргах боломжгүй баримт нотолгоотойгоор Ариун өдрийг сахисаар байжээ. “Тэр Амралтын өдөр бүр синагогт сургамжилж, иудейчүүд, грекчүүдийг итгүүлэхийг оролдож байв” (Үйлс 18:4). Итгэгч харь үндэстнүүд хүртэл энэхүү эшлэлд гарсанчлан еврейчүүдтэй адил Ариун өдрийг сахих ёстой хэмээн сургагдаж, тэр өдөр л Христэд итгэгчид болж байсан ажээ.

Үйлс номон дээрх эшлэлээс Христэд итгэгчид болон еврейчүүд бидний Аврагчийн үхлээс 30 -аад жилийн дараа ч Тэр болоод Түүний дагалдагч нарын сахидаг байсан цор ганц өдөр Ариун өдрийг маш тодорхой сахиж байсан гэдгийг нэгэнт дурдсан тул одоо Ариун өдөр(Бямба гараг) яагаад ингэж давуу дуудагдах болсон бэ гэдгийг, ариун бичээс дээр долоо хоногийн эхний өдрийн тухай юу гэж бичсэн байгаагаас уншиж, баримт нотолгоогоор хангах ажилдаа орцгооё.

Христийг дахин амилалтаас хойш Ням гарагийн тухай дурдсан эхний эшлэл Лук номын 24-р бүлэг мөн Иохан 20:19 дүгээр эшлэлүүдэд тус тус гардаг.

Эдгээр эшлэлүүдэд дагалдагчид зөвхөн хоорондоо уулзах зорилго тээн цугларцгаасныг л харуулдаг юм. Уулзсан өдөр нь дахин амилалтын өдөр (Ойрхи дорнодын Ням гараг) – т тохиосон бөгөөд энэ өдөр тэд хуучны Ариун өдөр (Бямба гараг) – ийг орхиж шинэ “ариун” өдөр үүсгэн эхлүүлэхээр цуглаагүй нь ямар нэгэн залбирал үйлдсэн, мөргөлд уриалан дуудсан эсвэл Судраас уншсан шинж тэмдэг илрээгүй зэргээс харагдах боломжтой. Харин тэд Иоханы маш тодорхой тэмдэглэн үлдээсэнчлэн “Иудэйчүүдээс айснаас” – аа болж цугларсан байлаа.

Ням гарагийн тухай дурдсан хоёр дахь хэсэг нь Иоханы Сайн Мэдээний 20:26–29 р эшлэлүүдэд гардаг: “Найман өдрийн дараа шавь нар гэрт дахин цуглахад Томас тэдэнтэй хамт байв.” Дахин амилсан аврагч энэ өдөр өмнөх уулзалтад байгаагүй Томасын эргэлзээг бусад дагалдагч нарын өмнө үгүй хийсэн юм. Аврагчын хувьд Тэрээр бүх дагалдагч нарынхаа өмнө амралтын өдрийг өөрчлөх боломж болж болох байсан ч энэ өдөр залбирал, магтаал мөн Судраас уншсан талаар ямар ч тэмдэглэл үлдээгээгүй билээ.

Дагалдагчид Ням гарагт цугларсан гуравдахь тохиолдол Үйлс 2:1 –д байх бөгөөд: “Пентекостын өдөр болоход тэд цөмөөрөө нэг газарт цугласан байлаа” гэсэн юм. (Пентекостын өдөр—Ням гараг) Тэгвэл одоо энэ эшлэл бидний Библийг баримтлагч Христэд итгэлт ахан дүүст маань Ням гараг Бямба гарагийг орлохоор болсон хэмээх багахан ч гэсэн найдвар авчирч чадахаар байна уу? Учир нь бид еврейчүүд Ариун өдрийг сахихынхаа хажуугаар Христ итгэл үүсэн бий болсоноос хойш Ням гарагийг 1500 жилийн турш буюу 18 үеэрээ сахиж ирсэнийг тэдэнд хэлэхэд тэд энэ эшлэлээс нэг их тайтгарлыг олж хардаггүй. Пентекост нь Дээгүүр өнгөрөх баяраас хойш 50 дах өдөр буюу долоон долоо хоногийн дараагийн Ариун өдөр гэж тооцогддог бөгөөд энэ нь Ням гараг байдаг ажээ. Ямар Израйль хүн 3000 жилийн турш тэмдэглэж ирсэн, долоо хоногийн эхний өдөр тэмдэглэдэг Пентекостын баярын өдрийн үүслийн шалтгааныг хүндэтгэхгүй байх вэ? Харин Библийг баримталдаг гэж нэрлэгддэг Христ итгэлтнүүд Есүсийн сахисаар ирсэн Ариун өдрийг гутаах далим олж Түүний шавь нар Еврейчүүдийн Пентекостын баярын өдөр болгон шинэчилсэн хэмээн хэлж Бурхан болоод тэдний өөрсдийн зааварлагч болох Библийн эсрэг тэрсэлсэн юм.

Өдрийг өөрчилсөн гэх үзэлд итгэдэг хүмүүсийн ашигладаг дараагийн эшлэл бол Үйлс 20:6-7 буюу “Долоо хоногийн эхний талх хуваахаар хамтдаа цуглах үед”. Мэдээж энэ эшлэл бидний нөхдийн хувьд үзэл санаагаа бататгах боломж өгч байж болох ч бид энэхүү саад бартааг үл харгалзан тэдэнд өөрсдийгөө няцаалгахыг хүлээн зөвшөөрч болохгүй. Бид үүнд дараах аксиомоор (туйлын үнэн буюу абсолют, илт үнэн) хариулна. “Күөд фробат нимис, фробат нихил” - “Хэт их баталгаа юуг ч баталдаггүй”. Бүгдээрээ эргээд Үйлс 2:46 - г харцгаая. “Өдөр бүр тэд нэг сэтгэлээр сүмд цуглаж, талхаа айлуудад хувааж” байлаа. Энэ эшлэлийн дэргэд мөнөөх Ням гарагийг онц гойд эрх дархтайг бататгах эшлэл агаарт хоосон найдвар болон замхарч байгааг хэн харахгүй өнгөрөх вэ? Библийг баримтлагч Христэд итгэгчид энэхүү эшлэлээр Ням гарагийн эрх мэдлийг тунхагладаг бол дагалдагчдын хийж байсан үйлдэл өдөр тутамдаа хийдэг энгийн зүйл байсан гэдгийг Лук бидэнд тодотгон

харуулж, “Өдөр бүр тэд нэг сэтгэлээр сүмд цуглаж, талхаа айлуудад хувааж” хэмээн тэмдэглэн үлдээжээ.

Эдгээрээс илүүтэйгээр Ням гараг Бямба гарагийг орлосон мэт санагдуулах өөр нэгэн эшлэл бий. Энэ нь Паулын бичсэн 1Коринт:1, 2 дээрх “Ариун хүмүүсийн төлөөх хуримтлалын талаар”, “долоо хоног бүрийн эхний өдөр хүн бүхэн бололцоогоороо цааш нь хийж хадгал” гэсэн байна. Паулын хүсэлтийг хүн бүхэн даган биелүүлсэн гэж үзээд бидний Аврагч дэлхий дээр байх үед Бямба гараг бүрт юу болдог байсан, мөн Түүнийг явсанаас хойш гучин жилийн дараа ч хэрхэн үргэлжилсэн талаар Үйлс номд хэрхэн бичигдсэнийг харцгаая.

Есүсийн дагалдагчид “Ариун өдөр бүр” Бурханы үгийг сонсохоор цуглаж судруудаас “Ариун өдөр бүр” уншдаг байжээ. Цааш судалваас, "Амралтын өдөр бүр тэрээр(Паул) синагогт иудейчүүд, грекүүдийг ятган үнэмшүүлэхээр ярилцдаг байлаа” хэмээн Үйлс 18:4 – д бичигдсэн байгаа. Ариун өдөр бүр Судруудаас уншиж, залбирч, мөн сургаал айлддаг байсан нь баттай атал эдгээр бүх зүйлсийг долоо хоногийн өөр нэг өдөр мөнгө хураах ганц хүсэлтээр өөрчлөгдсөн гэж дүгнэхээс илүү өөр ямар утгагүй дүгнэлт байх билээ?

Энэхүү эшлэлийн үнэ цэнийг бүрэн утгаар нь хүлээн авахын тулд Христийг нас барсан Баасан гарагт Түүний эх болон шавь нарын юу хийснийг санах хэрэгтэй. Тэд Есүсийг загалмайгаас буулгасны дараа тос болоод маалинган даавууг худалдан аваад, “Бурханы ариун” Амралтын өдрийг өнгөртөл хийж байсан бүхнээ хойшлуулж, Ням гарагийн өглөө Түүнийг оршуулах ажлаа үргэлжлүүлэхээр очсон байдаг.

Тэд яагаад оршуулах ажлаа Бямба гарагтаа хийчихэж болоогүй юм бэ гэж үү?. Учир нь Зааварлагчийнхаа биеийг оршуулах ажил нь хатуу чанга сахигдаж ирсэн Ариун өдөртэй давхцаж байсан учраас бөгөөд энэ нь өмнөх эшлэл дээр гарсан шиг ням гараг Ариун өдрөөс илүү чухал байр суурьтай гэдэг ойлголтыг няцаахад хангалттай юм. Паулын мөнгө цуглуулах хүсэлт болон Есүсийн биеийг оршуулах зэрэг үйл явдлууд Ариун өдөрт ямар ч нөлөөгүй бөгөөд харин үүний дараагийн өдөр болох долоо хоногийн эхний өдөр буюу Ням гарагт үйлдэгджээ.

Шинэ Гэрээн дэх Ариун өдөр(Бямба гараг) болон долоо хоногийн эхний өдөр (Ням гараг) – ийн тухай дурдагдсан бүх эшлэлүүдийг судалж, эдгээрт нарийвчилсан дүгнэлт гаргах аваас үүнд Ням гараг Бямба гарагийг орлох болсон гэх ойлголтын өчүүхэн ч хэлтэрхий харагдахгүй. Тэгэхээр одоо бидэнд “Эзэний өдөр” хэмээх үгний утгыг ойлгох л үлдээд байгаа бөгөөд дараагийн дэд бүлэгт судалж, биднийг үзэл бодлоо зөвтгөх боломжгүй, өөр хоорондоо таарч нийлдэггүй баталгаа гаргадаг, мөн өөрийгөө сүйрэл рүү хөтлөх үзэлтэй гэгдэх шашны системийн үл зохицолдолгоонд тохирожтой хариултуудыг дурьдан дүгнэх болно.

[1893 оны 9-р сарын 23-ны “Catholic Mirror” (Католик толин тусгал)]

"Доголон таяган дээр тэмтчин зогсож

Нэг хөлөө үнэнээр, нөгөөг нь худлаар түшүүлвэл

Дайвахгүй хурдаар зорилго өөдөө догонцож

Юуг ч хүртэлгүй уралдаанд ялагдана"

Энэ хэсэгт бид Библийг баримтлагч Христэд итгэгчдийн Бурхан Ням гарагийг дагалдагчын бичээсүүд дэх(апостолик бичээсүүд) Ариун Сүнсээр бичигдсэн тэнгэрлэг хүслийн дагуу мөргөл үйлдэх шинэ хууль өгч, Бямба гарагийг орлуулсан хэмээх шинэ бөгөөд эцсийн баталгааны тухай судлах болно.

Бичээсүүдэд “Эзэний өдөр” хэмээх хэллэг гэнэтийн байдлаар маш олон газруудад дурьдагдаж байгааг бид мэднэ.

“Ариун өдөр” – тэй холбоотой эшлэлүүд Шинэ Гэрээний Сайн мэдээний номнууд, Үйлс болон Паулын захидлуудад нийтдээ 61 удаа гардаг бөгөөд долоо хоногийн эхний өдөр болох Ням гарагийн тухай сүүлийн үеийн тооллогоор 7-8 удаа гардаг ажээ. Тэдгээрээс Бурхан амралтын өдрийг сольсон хэмээх ямарч баталгаа олддоггүй бөгөөд одоо бид гурав дахь сэдэв буюу Бурханы нэрийг барьж, дэлхийг тэр чигт нь мэхлэн, өөрсдийн зааварлагч болсон Библиэс баталгааг олж чадаагүй Библийн системийн эцсийн хэсэг бүлэг текстийг дэлгэрүүлэн үзэх гэж байна.

Эхний эшлэл нь Үйлс номын 2:20 – д гарах бөгөөд “Эзэний агуу, цог жавхлант өдөр ирэхийн өмнө Нар харанхуйлж, сар цус мэт болно” хэмээх эшлэлүзүүлэг өгөгдсөнөөс хойш хэдэн Ням гараг өнгөрсөн бэ? Энэхүү эшлэлийн үнэн утгийг гуйвуулж, шүүлтийн өдрийг Ням гараг руу шилжүүлэх гэж ямар их хичээл зүтгэл гаргав!

Энэ сэдэвийн хоёр дахь эшлэл бол 1Коринт 1:8 " Тэр та нарыг Эзэн Есүс Христийн маань өдөр гэм зэмгүй байлгахаар төгсгөл хүртэл бататгана." Ямар хүн дагалдагчид энэ эшлэл дээр шүүлтийн өдрийг хэлж байгааг уншаад ойлгохгүй байна вэ? Дараагийн эшлэл нь уг номын 5:5 “махбодыг нь сүйрүүлэхийн тулд тийм хүнийг Сатанд тушаая гэж шийдэв. Ингэснээр түүний сүнс Эзэн Есүсийн өдөр аврагдаж болох юм.” Энэхүү бузартсан Коринт хүн ням гарагт аврагджээ. Үүнийг гуйвуулах нь өрөвдөлтэй хэрэг! Дөрөв дэхь эшлэл 2Коринт 1:13, 14: “Та нарын уншиж, мэддэгээс өөр юмыг бид та нарт бичдэггүй. Та нар эцэс болтол бүрэн мэднэ гэдэгт би найдахдаа та нар биднийг зарим талаар мэдсэн шиг бидний Эзэн Есүсийн тэр өдөр бид та нарын, та нар бидний сайрхал болно хэмээснийх билээ.” Уг өдөр нь Ням гараг уу эсвэл шүүлтийн өдөр үү? Аль нь вэ?

Тав дахь эшлэл нь Паулын Филиппойчуудад илгээсэн захидалын эхний бүлгийн 6 дугаар эшлэл: “Та нарт сайн үйлийг эхлүүлсэн Тэрээр үүнийгээ Христ Есүсийн өдрийг хүртэл төгс болгоно гэдэгт би бат итгэж байна.” Дараагийн Ням гарагт нь сайн байдлаа төгс болгосон мөнөөх Филиппой хүн өнөөдрийн бидний маргаад байгаа өөрчлөлтийг хараад инээд нь хүрэх биз!

Зургаа дахь эшлэлийг бараг уншаад ч хэрэггүй гэмээр. Филиппой нэгдүгээр бүлэг 10 дугаар эшлэл “Ингэснээр та нар Христийн өдөр хүртэл цэвэр, гэмгүй байхын тулд аль сайныг дэмжих юм.” Тэр өдөр нь дараагийнх нь Ням гараг юм байх. Нэг их удаан хүлээхээргүй л байж. Долоо дахь эшлэл 2Петр 3:10 “Гэвч Эзэний өдөр хулгайч мэт ирэх болно.” Энэ эшлэлийг Ням гарагтай холбож тайлбарлавал утгагүй юм гэж хэлэхэд ч багадана.

Найм дахь эшлэл 2Петр 3:12 “Бурханы өдөр ирэхийг хүлээж, түргэлүүл. Тэр өдөр тэнгэр шатан устаж, язгуур юмс түймэрт хайлах болно.” Энд бичсэн Эзэний өдөр нь өмнөх эшлэлтэй адил утгатай бөгөөд эдгээрийг Ням гарагтай холбон тайлбарлавал Христэд итгэгчид Бямба гарагийн орой унтаж чадахаа болих биз.

Судрын эшлэлүүдийг хутгаж “Эзэний өдөр” -ийг Ням гараг болгон бусдыг мэхлэх гэсэн есөн эшлэлийн наймыг нь бид уншчихлаа. Гэвч ямар үр дүн гарав? Хэн ч шууд хараад л дэлхийн төсгөлийн өдрийн талаар хэлж буй гэдгийг ямар ч асуудалгүй ойлгохоор байна.

“Эзэний өдөр” – ийн тухай сүүлийн эшлэл бол мөн л апостолик буюу дагалдагчдын бичээсээс олдоно. Илчлэлт 1:10 – т Иохан хэлэхдээ “Эзэний өдөр би Сүнс дотор байсан”. Энэ эшлэл бидний Библийг баримтлагч найзуудад маань өмнөх тайлбаруудаас илүү төвөг болно. Иохан сайн мэдээний номууд болон захидлууддаа энэ хэллэгийг өмнө нь хэрэглэсэн үү? – Мэдээж үгүй. Энэ хүртэл тэрээр Ням гарагийн тухай дурдсан уу? – Тиймээ хоёр удаа. Эдгээртээ Ням гарагийг юу гэж нэрлэсэн бэ? (Иохан 20:1) “Долоо хоногийн эхний өдөр”.

Ахиад Иохан 20:19 дээр: “Долоо хоногийн эхний өдөр буюу тэр өдрийн үдэш.” Тэрээр өөрийн сайн мэдээ болон захидлууддаа эш үзүүлэлг хүлээн авч бичсэн ч Ням гарагийг “долоо хоногийн эхний өдөр” гэж дууджээ. Тэгвэл ямар үндэслэлтэйгээр түүнийг энэ үзлээ хаясан гэж хэлэх вэ? Тэр Илчлэлт номыг бичихдээ илүү их эш үзүүлэлг авсан юм уу эсвэл арай шинэлэг загварлаг байх гэж ням гарагт шинэ нэр өгөө юу?

Лук, Паул, Петр нар яг адилхан хэллэгийг өмнө нь найман удаа бичсэн байгааг харахад тэдгээрт эш үзүүлэгийг өгсөн Ариун Сүнс Иоханд тусад нь өөр эш үзүүлэлг өгч Ням гарагийг шүүлтийн өдөр болох “Эзэний өдөр” гэж дуудуулахгүй байгаагаас харвал дээрх асуултуудад өгөх хариулт хангалттайгаас ч илүү хангалттай байх биз. Ингээд няцашгүй тодорхой байдал болоод эдгээрийн төстэй байдлаар бид найман удаагийн давтагдсан утга санааг туйлийн ойлгомжтой болгож, тайлан дүгнэлт хийвэл бүх есөн эшлэлийг Ариун Сүнсний эш үзүүлэлгээр бичсэн гэдгийг санагалзан үзэхийн хажуугаар дээрх 9 эшлэл бүгд адилхан зүйлийн талаар бичсэн байгааг ойлгож авлаа.

Эдгээрээс цааш өөр эшлэлүүдийг санал болгосон ч тэд бүгдээрээ адил утга санааг агуулдаг. Иохан Илчлэлт номын 1:10 дээр: “Эзэний өдөр би Сүнс дотор байсан” гэж хэлсэн ч үүнийгээ тодорхой болгох үгсийг дөрөвдүгээр бүлгийн нэг хоёрдугаар эшлэлүүдэд бичсэн байдаг. “Үүний дараа би тэнгэрт нээлттэй хаалгыг харав” түүнд дуу сонсогдож, “Наашаа гараад ир. Үүний дараа юу тохиолдох ёстойг Би чамд үзүүлэе гэлээ.” Бүгдээрээ сүнс дотор Иохантай хамт хөөрье. Хаашаа гэж үү? Тэрхүү “тэнгэр дэх нээлттэй хаалга” руу буюу тэнгэрийн улс руу. Бид юу олж харах бол оо? Үүний дараа юу тохиолдох ёстойг, дөрөвдүгээр бүлгийн эхний эшлэл дээр гарна. Иохан Сүнс дотор тэнгэр лүү өргөгджээ. Тэрээр урьдаас

болох юмсыг бичих ёстой болсон бөгөөд шүүлтийн өдөр бол “Эзэний өдөр” гэдэг нь энд тодорхой харагдаж байгаа юм.

Бид маш нарийвчлалтайгаар Шинэ Гэрээн дээр байдаг Христитгэл дунд нэг өдрийг нөгөөгөөр сольсон буюу хуучирсан хууль гэгдэх Ариун өдрийн хуулийг цуцалсан гэх ойлголтыг дэмжихэд ашигладаг бүх эшлэлүүдийг авч судаллаа. Бид дээрх тайлбаруудыг болгоомжтой, нягт нямбай гаргасан бөгөөд гуравдугаар(Католик сүмийн дарааллын хувьд Ариун өдрийн хууль гурав дахь хууль гэж тооцогддог) хууль шинэ хуулийн дор цуцлагдсан гэдэг ойлголтыг эргэцүүллээ. Гэвч эдгээр нь 1874 оны Методист Хамба лам нарын уулзалтаар цуцлагдаж тэр жилдээ Нью Юор Хералд – аар эш татагдсан бөгөөд үүнд дурдахдаа “Анхнаасаа байсан бөгөөд Мосе болон үе үеийн эш үзүүлэгчдээр баталгаажиж ирсэн Ариун өдөр хэзээ ч цуцлагдаж үгүй болоогүй. Уг хуулийн өчүүхэн ч хэсэг, хэлтэрхий нь ариун чанараа алдаагүй” гэжээ. Энэхүү тунхаглал нь Библийг баримтлагч итгэгчдийн дийлэнх хэсэгийг гуравдугаар хуулийг шинэ хуулийн дор ороход нөлөөлсөн юм.

Бид дахин уншигчдаа Нийтлэг залбирлууд номын “39 зүйлийн 20 дахь” хэсэгт анхаарлаа хандуулахыг хүсэж байна: “Бурханы үгийн эсрэг юуг ч хүлээж авах нь сүмийн хувьд хуулийн эсрэг юм.”

Дүгнэлт

Бид энэхүү товхимолыг бичихдээ уншигчдынхаа хүсэлтийн дагуу Бурханы үгэнд суурилсан бат бөх, няцашгүй дүгнэлттэй, мөн баримтууд бүхий материал бэлдэж өгөх гэж шаргуу ажиллалаа. Библийн систем арван зуравдугаар зуунд хэлбэржиж эхлэх үед энэ нь сүмийн байр сууриас гадна загалмайтнуудын дайн тулаанаар Үүсгэгчийнхээ бүхий л шинж чанарууд гээд байж болох бүхий л зүйлсийг сүйтгэж орхисон бөгөөд тэдэнд Христ итгэлийн үзэл суртал, ёс суртахууны зааварлагч болсон Библи л бүрэн үлджээ.

Тэдний итгэлд хамгийн том байр суурь эзлэх сэдэв бол тэр үед ч өнөөдөр ч Ариун өдрийг ариунаар сахих нь хэвээр байсаар байна. Бүр цаашлаад энэ бол өнгөрсөн 300 гаран жилийн хугацаанд Христ итгэлтнүүдийг тоолж баршгүй олон удаа хуралдуулж, чуулган явуулсан цор ганц сэдэв юм. Ариун өдрийг сахих нь Библийн онолын гол хураангуйлал буюу цөм болж байдаг. Долоо хоног бүр Католик орнуудад Ариун өдрийн тухай, эсрэгээрээ Библийг баримталдаг орнуудад өөрсдийгөө хөөргөсөн хуурамч өдрийн тухай замбараагүй номлолууд индэрт хангинасаар л. Дэлхийн үзэсгэлэнгийн яармаг Ням гарагт эхэлсэнтэй холбогдуулсан асуултууд шийдэгдээгүй байхад бүхий л Протестант урсгалын индэр болоод манай улсын өнцөг булан бүрт суусан Библийг баримтлагч номлогчдын эгдүүцлийг хэн мартаж чадах билээ. Тэрхүү үзэсгэлэн дээр өөрсдийн үзэл санааг агуулсан хайрцгийг дэлгээгүй шийдвэрт нь эгдүүцсэн ганц шашны урсгал байгааг хэн мэдэхгүй гэж?

Библийг чадамгайгаар мэхэлж байгаа эдгээр сайн нэр зүүсэн итгэгчид Аврагчын цаг үеэс өөрсдийн өрөөсөн талыг олж харах биз. Аврагч тэдэн шиг Ариун өдрийг зөвхөн үзэмж байдлаар сахиагүйн төлөө, тэд аврагчыг өдөр шөнөгүй мөрдөн мөшгиж, хэмжээлшгүй их ачаа дарамт үзүүлж, тэвчээрийн хязгаараас хэтрэхээр их занал учруулж байсан юм.

Тэд аврагчын шүүмжлэлийг үзэн ядсан бөгөөд Тэрээр фарисайчуудын бардам занг бүрэн гүйцэд тодорхойлох үгийг ч хүний үгсийн сангаас олж чадаагүй юм. Тэнгэрлэг Нэгэний энэ бодол өдгөө ч энэхүү 19-р зууны эцэст ч тэдний дагалдагчид болоод тэднийг дэмжигчдийн тухайд бодлоо өөрчлөөгүй бололтой. Гэвч энэ бүгд дээр нэмж хэлэх нэг зүйл гэвэл эрт үеийн Фарисайчууд Ариун өдрийг сахидаг байсан бол өнөөгийн фарисайчууд өөрсдийн гэнэн эсвэл тэнэг зангаас болж өөрсдийн их Зааварлагчийн үхэх хүртлээ сахиж, цаашлаад дагалдагч нар нь ч сахиж байсныг Ариун Бичээст тэмдэглээтэй байхад нэг ч удаа жинхэнэ Ариун өдрийг сахиж үзээгүй бөгөөд эдгээрээс улбаалан Библийг баримтлагч Христэд итгэгчдийн үйлсээс өнөөдөр бидэнд санаатайгаар гутаан доромжилсон мөргөөлдөөн улам эрчимжиж байгаа нь харагдаж байна. Протестантизмийн гол уриа болж чадах үг бол Библи мөн Ариун өдөр юм. Гэвч бид Библи, Ариун өдрийн эсрэг гэдэг уриатай болчихсон байгааг дэлгэн үзүүлээ. Тэдний онол болоод үйлсээс илүү эсэргүүцлээ илэрхийлэх зүйл байхгүйг бид бас илчиллээ. Цаашлаад тэд болоод тэдний Библийн эцэг өвгөд хүртэл амьдралдаа нэг ч удаа Ариун өдрийг сахиж байгаагүйг бид батлав.

Израйльчууд болон Долоо дахь өдрийн Адвентистууд л Бурханаар сонгогдож, Тэрээр Өөрөө нэрийг нь айлдсан тэрхүү өдрийг сахиснаар бусад итгэгчдийн хувьд бузар болсон бөгөөд тэд өөрсдийн зааварлагч болсон Библийг үгүйсгэж, үл тоон Католик сүмийн сахидаг өдрийг өвлөн авсан билээ. Эхлэлээс Илчлэлт хүртэл тэдний зааварлагч болсон Библи нь Бямба гарагийг сахих нь Бурханы хүсэл гэдгийг эрүүл саруул ухаанаараа уншсан ямар протестант хүн Түүний хуулийг үл сахиж чадах вэ?

Дэлхийн түүхээс үүнээс илүүтэйгээр тэнэг, бодит үнэнийг үгүйсгэсэн өөрийгөө гутаан доромжлогчын жишээг олж чадахгүй. Бүгдээр “цор ганц үнэн зааварлагч” гэж өргөмжилсөн Библийн хуудас бүрт Ариун өдрийн хуулийг долоо хоног бүр сахих ёстойг илчилсэн байхад түүнийг дагагчид ганц удаа биш бүр 300 жилийн туршид энэхүү хуулиа дагасангүй! Библийг баримтлагч Итгэгчдийн томоохон хэсгүүд болох Методист сүмийнхэн Ариун өдрийг хэзээч цуцлагдаагүй гэдгийг тунхагласан бөгөөд Английн сүмийн дагагчид, мөн тэдний охин сүм болох Америкийн нэгдсэн улсын Эпископал сүмийнхэн шашны хорьдугаар зүйлийн дагуу захирамж гаргаж, Сүм “Бурханы үгийн эсрэг” юунд ч тунхаглал гаргахгүй гэдгээ мэдэгдсэн. Бурханы үг Ариун өдрийг сахих ёстойг дахин дахин, хамгийн ойлгомжтойгоор илэрхийлдэг бөгөөд үүнийг эсэргүүцсэн нэгнийг үхлийн шийтгэл хүлээж байгааг хамгийн эерэг байдлаар дүрсэлсэн байдаг. Библийн бүхий л хэсэгт яг үүнийг дурдсан байдаг бөгөөд өөрсдийгөө зөвтгөх ямар ч тайлбар үүнд нэмэргүй.

Энэхүү өрөвдмөөр нөхцөл байдалд Ариун Сүнсний үгс хэр үнэнээр хэрэгждэг бол! *"Iniquitas mentita est sibi"*- “Гэм буруу нь өөрийгөө хуурлаа.” Зөвхөн Библийг зааварлагчаа болгон дагах ёстой ч дэлхий цор ганц зааварлагчаа гутамшигтайгаар түлхэн хаясан. Харин “Жигшүүрийн эх” болсон Католик Сүмийн сургааль болоод зан үйлийг тэд өөрсдийн хэрэгцээнд тааруулан хүлээн авч, “Ариун өдрийг ариунаар сахь” хэмээн хатуу сануулсан

Бурханы үгийн эсрэг зогссон юм.

Эдгээр цувралыг дуусгахынхаа өмнө бид уншигч та бүхнийг дараах хоёр зүйлд анхаарлаа дахин нэг хандуулаасай гэж хүсэж байна. 1. Христ итгэлийн Ариун өдөр, Католик сүм болон түүний түшиг Ариун сүнсний нэгдлийн жинхэнэ үр жимс 2. Протестантизмийн бүх талаараа үндэслэлгүй, өөртэйгөө зөрчилдсөн өөрийгөө үгүйсгэсэн гэж үзэгдээд байгаа тунхаглал.

Нэгдүгээр мэдэгдэлд бага зэргийн баталгаа хэрэгтэй. Католик Сүм Протестантуудыг үүсэн бий болохоос мянга гаруй жилийн өмнө өөрсдийн тэнгэрлэг эрх мэдлийн дор Бямба гарагийг Ням гарагруу шилжүүлсэн билээ. Бид түүнийг өөрийн тэнгэрлэг эрх мэдлийн дор гэж хэлж байгаагийн шалтгаан гэвэл Өөрийгөө “Ариун өдрийн Эзэн” гэх Тэр нэгэн түүнд заах эрхийг нь өгсөн бөгөөд Өөрт итгэгчиддээ харь үндэстнүүд болон татвар хураагчид” – тай хамт үлдээнэ гэдэг шийтгэл дор “Та нарыг сонсдог хүн намайг сонсдог” гэж тушаан түүний үгсийг сонсгосон бөгөөд дэлхийн төгсгөл хүртэл түүнтэй хамт байна гэж амалсан юм. Тэрээр өөрийн эрх мэдлээ Түүнийх юм шиг л үүрд мэтээр төсөөлөн барин зогсож байгаа. Протестант урсгал үүсэн бий болохдоо л Христэд итгэгчдийн Ариун өдөрт гүн суурилж, үүсэлд нь хүртэл ухаж ямар нэгэн цэгцтэй хариулт зөвтгөл хайж эхэлсэн бөгөөд үүний улмаас өдрийг өөрчлөх сүмийн эрх мэдлийг хүлээн зөвшөөрч 300 жил өнгөрсөн байна. Тиймээс Христэд итгэгчдийн Ариун өдөр нь өнөөдрийг хүртэл Католик сүм болоод түүний түшиг Ариун Сүнсний нэгдмэл байдлын үр жимс болсон бөгөөд энэ нь Протестант урсгалаас ямар ч эсэргүүцэлгүйгээр оршсоор байгаа.

Тэгвэл одоо бүгдээрээ хоёр дахь эргэцүүллийг харвал Библи буюу бидний зааварлагч маань байж болох ямар ч шалтгаанаас үл хамааран өдрүүдэд өөрчлөлт оруулахийг бүрмөсөн хориглосон байгаа нь илт харагддаг. Энэ хууль бол бидний “мөнхийн гэрээ” юм. Харин бидний зааварлагчийн сахиарай гэж хэлсэн өдөр огт сахигдахгүй байсаар л. Тийм учраас өөрсдийгөө зөвтгөх зөвтгөлийг өөртэйгөө зөрчилдсөн, өөрийгөө хуурсан, өөрийгөө явж явж үгүй хийсэн, хүний хэлээр хэлэхэд ч бэрх байдлаар хайсаар.

Энэ ёс суртахуунгүй байдал хязгаараа даваачгүй харин ч хол байгаа мэт. Тэдний Католик Сүмийн өврөөс гарж зугтсан нэрийдэл нь үнэндээ Библид бичигдсэн үнэний үгнээс нүүр буруулхын тулд л байсан юм. Тэд Бурханы үгийг өөрсдийн цорын ганц зааварлагч хэмээн хүлээн авсан мөртлөө энэ сэдвийн дор бидний ярилцаж баталсаны дагуу нэг их удалгүй орхичихсон бөгөөд өөрсдийн хүслээрээ бузар булай байдал нь багадаж, Католик Сүмийн сургаалийг хүлээн зөвшөөрч өөрсдийн зааварлагчийнхаа маш тодорхой, ойлгомжтой хэлж байгаа итгэлийнхээ хамгийн чухал үзэл сурталын эсрэг явж байгаа нь тэднийг “тохуурхал, төөрөгдөл, урхи” дунд явж байна уу гэлтэй.

[Эдиторын тэмдэглэл –Яг энэхүү гол шалтгааны улмаас Трентын Зөвлөл Хувьсгалыг буруутгасан юм. Энд бичигдсэний дагуу Хувьсгалчид Католик Сүмийг Бурханы үгэнд бичигдсэн үнэнийг орхисон хэмээн тайлбарлаж байв. "Бичигдсэн үгс," "Библи, мөн зөвхөн Библи," "Хэмээн Эзэн хэлэв," зэрэг нь тэдний уриа үгс байлаа. Түүнчлэн "Зөвхөн үгээр бичигдсэн Судар л үнэний хэмжүүр." Энэ бол Хувьсгал буюу Протестантизмийн тунхаглал байлаа. "Судар ба Уламжлал." "Сүмийн тайлбарын дагуух Библи ба эцэг өвгөдийн санал

нийлсэн зөвшилцөл" энэ бол Католик Сүмийн байр суурь болон тунхаглал байсан ажээ. Энэ бол шинэчлэгчид Европын анхаарлыг татахад хүргэсэн асуудлуудыг авч үзэхийн тулд Трентийн зөвлөлд хуралдсан томоохон асуудал байв. Зөвлөлөөр хэлэлцсэн итгэлийн эхний асуултууд нь энэхүү асуудалтай холбоотой байв. Уламжлалаас татгалзаж, зөвхөн библийг эрх мэдлийн жишиг болгохыг эрхэмлэдэг хүмүүс католик шаашинтнуудаас бүрдсэн хүчирхэг нам, зөвлөлийн дотор хүртэл байсан юм. Энэхүү үзэл бодол нь зөвлөлийн хэлэлцүүлэгт маш их нөлөөтэй байсан тул Пап ламын төлөөлөгчид түүнд "уламжлалыг бүрмөсөн орхиж, Библийг дэмжин уриалж, цорын ганц жишиг болгох хандлага хүчтэй байна" гэж бичжээ. Гэвч ингэж протестантуудын үзэл бодлыг зөвтгөхийн тулд ихээхэн урт удаан хугацааг туулах болно хэмээжээ. Тэгээд зөвлөлийнхөн энэхүү асуудлыг шийдвэрлэх үеээр "Ариун бичээс ба уламжлал" нь католик шаашны цорын ганц, найдвартай үндэслэл гэж бусдад итгүүлэхэд хүргэсэн юм. Зөвлөл шинэчлэлийг буруушаах тогтоол гаргахын тулд үүнийг заавал хийх хэрэгтэй бөгөөд, эс тэгвээс чадахгүй болох болно. Зөвлөлийг түр зогсоох хүртэл энэ асуудлыг өдөр бүр хэлэлцэж байв. Эцэст нь, толгой гашилгасан энэ хэцүү асуудлаар хамба Рэгжо зөвлөлд орж ирэн, "зөвхөн Библи" гэгч нэхэмжлэгч нарт дараах зан үйлийн талаар шаардлага тавьжээ.

"Протестантууд зөвхөн бичигдсэн үгс хэмээн ярьдаг. Тэд зөвхөн библийг итгэлийнхээ үндэс гэж үздэг. Тэд сүмүүдийг Библиэс гажин, уламжлалыг дагасан гэж үзэн өөрсдийн гаргасан бослогоо зөвтгөдөг. Протестантуудын зөвхөн бичигдсэн үгс дээр тулгуурладаг гэдэг нь үнэн биш юм. Зөвхөн библи л итгэлийн жишиг гэсэн тэдний мэдэгдэл худал юм. БАТАЛГАА: Бичээс дээр долоо дахь өдрийг Амралтын өдөр болгон сахих талаар тодорхой харуулдаг байна. Тэд долоо дахь өдрийг сахидаггүй, харин үгүйсгэдэг. Хэрэв тэд үнэхээр Ариун Судрыг өөрсдийн итгэлийн үндэс болгон үздэг бол Библид заасны дагуу долоо дахь өдрийн талаарх хуулийг дагаж мөрдөх хэрэгтэй. Гэвч тэд библид бичигдсэн Амралтын өдрийг сахихаас татгалзаад зогсохгүй, ням гарагийг сахих нь тэдэнд буй ганц сүмийн уламжлал гэдгийг хүлээн зөвшөөрч, мөн үүнийгээ хэрэгжүүлдэг. Үүний үр дүнд "зөвхөн Библи" гэсэн байр суурь бүтэлгүйтэн үгүй болж, "Библи ба уламжлал" гэсэн үзэл бий болж, бүрэн батлагдсан бөгөөд протестантууд өөрсдөө шүүгчид болжээ."

Протестантууд өөрсдийн итгэл үнэмшлийн мэдэгдэл буюу 1530 оны Августбургийн тунхаглалд "Эзэний зүй ёсны мөргөлийн өдрийг сахихыг "Сүм" шийдсэн бөгөөд үүнийг бид хүлээн зөвшөөрсөн тул тойрч гарах боломжгүй байв" хэмээв.

Энэхүү мэтгэлцээнийг түлхэц өглөө хэмээн зөвлөл тунхагласан юм. "Зөвхөн бичээс" гэсэн талынхан бууж өгсөн юм; Мөн зөвлөл санал нэгтэйгээр Протестантизм бол Католик шаашныг бүхэлд нь нураах гэсэн, эрх мэдлийн төлөөх шударга бус бослого гэж буруушаав.; 1546 оны 4-р сарын 8-нд хоёр тогтоолыг нийтэлсэн бөгөөд эхнийх нь "Библи болон уламжлалыг" адил тэгш гэж хүлээн зөвшөөрч, хүндэтгэх ёстой бөгөөд эдгээр нь герман хэл дээрх Дойче Каноны {шиферлэгдсэн} ботьноо буй Библийн нэгэн хуулбарлагдсан хэсэг юм. Хоёрдахь тогтоол нь Вулгейтийг цорын ганц жинхэнэ, стандарт Латин хувилбар гэж тунхаглаж, анхны хуулбарыг орлож болохуйц хэмээн үзлээ. Мөн сүмийн үзэл баритлалын эсрэг Библийг тайлбарлахыг хориглоно. "Эцэг ламтнууд санал нэгтэй зөвшөөрсөн ч гэсэн" гэх мэт...

Ийнхүү энэ тогтоолуудаараа протестантизм ба протестантын зан үйл хоёрын хоорондох зөрчилдөөн нь Католик сүмд протестантизмын бүхэл бүтэн шинэчлэлийн хөдөлгөөнийг сүмийн эрх мэдлийн эсрэг хийн, амиа хичээсэн, амбицтай бослого гаргасан гэж буруушаах үндэс суурийг тавьж өгсөн юм.

Энэхүү том маргааны протестантуудын зөрчилдөөнд цэг тавьсан, эцсийн шийдвэр болох гол цөм нь бичвэрт бичигдсэн долоо дахь өдөр болох Их Эзэний Ариун өдрийг үгүйсгэж, уг өдрийг католик сүмийн зарлиг ёсны дагуу ням гараг руу шилжүүлж, дагаж мөрдөх явдал байв.

Бодит байдал дээрх энэ маргааны хоёр талуудын байр суурь ийм байна. Өнөөдрийн нийтлэл дээр дурдсанчлан энэ бол Католик сүм, протестантизмыг шүүж буй амин чухал асуудлын талаар бөгөөд нэр хүндтэй протестантизмыг "өмгөөлөх боломжгүй, өөртэйгөө зөрчилддөг, сүйрлийн хандлагатай" гэж үзэн үүн дээр нь тэдний үйл явцыг буруушааж буруутгаж байгаа хэрэг юм. Эдгээр протестантууд юу хийж, протестантизм нь юу болох вэ?]

Библи дэхь Ариун өдөр буюу албан ёсны мөргөлийн өдрийг гуйвуулж, гутаан доромжилж буй тэдний эрлийз тэжээвэр амьтдын эсрэг тэмцэгч, дуу хоолойгоо өргөдөг тийм сүсэгтэн хэн ч бай, бичээсийн үгс болон логик зөрчилдөөний маргаанд оролцох талаар сайн бодоорой. Тэдний тархай бутархай, хуурамч мэдээлэлээр дүүрэн, энэ байр суурийг нь засаж залруулж нэгэн цогц ойлголт болгоход нь бидний зүгээс чин сэтгэлээсээ, хүндэтгэлтэй хандан туслах болно гэдгээ амлаж байна.

Гэхдээ бид эдгээр эрхэм хүмүүсийг дэндүү сайн мэддэг гэдгээ уншигчдадаа баталж чадна. Мөн тэд ч биднийг дэндүү сайн мэддэг юм. Өөрөөр хэлбэл судрын эсрэг тэрслэх асуулт цаашид ирэх бөгөөд бид улам гүнзгий судлах хэрэгтэй болно. Одоо тэдний урдаа барьж байгаа бодлого "чимээгүй байх" бөгөөд үүнийгээ хэрэгжүүлэх нь гарцаагүй.

ХАВСРАЛТ I

Няцаашгүй эх сурвалжуудаас ирдэг, тодорхой бус өнгө аястай уг нийтлэлийг дахин хэвлэн, ухуулах хуудсыг хэвлэн нийтлэгчид эдгээрийг илгээсэн болно. Учир гэвэл энэ нь хэсэг хугацааны туршид орших, ням гарагт хийгддэг мөргөлийн тогтоолыг дагаж мөрдөх эсэхийн талаарх маргааны сүүлийн үе шат нь одоо юм. Мөн энэ нь бас анхдагч улс орнуудын асуудал төдийгүй олон улсын асуудал юм. Бид ийм асуудалтай байгаадаа баяртай байгаадаа бус, харин үүнээс холхон байгаасай гэж хүссэндээ юм. Дэлхийн өнцөг булан бүрт байгаа протестантууд өөрсдийн үзэл бодол, зан үйлдээ маш тууштай байж Ром болон тэдгээрийн хооронд урд өмнө нь байгаагүй тэр харилцааны хэлбэрийг үүсгэх боломж хэзээ ч гарч ирэхгүй гэдэгт бид итгэдэг.

Гэхдээ энэ нь асуудлын нөхцөл байдал энд дурдсан шиг байгаад юм. Үнэнээс бид

зугтах боломжгүй юм. Тиймээс уг асуудлын үнэнийг одоогийнх шигээ олон нийтэд таниулах нь Олон улсын шашны эрх чөлөөний нийгэмлэгийн үүрэг болж байна. Бидний ийм байдалтай байгаа нь таатай зүйл биш юм. Биднээс бусад өөр хэн ч байсан эдгээр зүйлстэй орооцолдохыг хүсэхгүй байхсан.

Одоо энэ асуудал яг ямар хандлагатай байгаа, тэр чигээрээ нь хүлээж авахыг бид олон жил хүлээсэн нь үнэн бөгөөд энэ талаар ухуулах хуудсанд маш тодорхой бичсэн байдаг. Бид хүмүүст, ялангуяа протестантуудад удаа дараа ням гарагийн хууль тогтоомжийн талаар сануулан хэлж байсан билээ. Тэр ч бүү хэл шашны хувьд бүхий л эрх мэдлийг нь эзэмшдэг Ром зааврын дагуу хөдлөхийг зааж, АНУ-ын ням гарагийг мөргөлийн өдөр хэмээн хүлээн зөвшөөрөн, албан ёсны хууль болгохыг дэмжиж байсан хүмүүст хүртэл “Та амжилтанд хүрсэн ч гэсэн, Ром та нарт хариуцлага хүлээлгэх нь гарцаагүй. Яагаад ням гарагийг сахих ёстой гэж?” хэмээн хэлсэн байдаг. Бидний олон жилийн турш хүмүүст хэлж байгаа энэ зүйл биелэх нь дамжиггүй. Тэр цаг нэгэнт ирсэн тул аль болох олон хүнд мэдүүлэх нь бидний үүрэг юм.

“Яагаад Ромд өмнө нь ийм зоригтой гарч ирээгүй юм бэ?” гэж бодож магадгүй юм. Юуг тэгтлээ их удаан хүлээсэн юм бол? Өмнө нь ийм зүйл хийх нь тэдэнд ашиггүй байсан билээ. Тэд хөдлөх шаардлагатай болсон үедээ өөрт нь хараахан байхгүй хүч чадлаар хөдлөхийг хүссэн юм. Гэвч Америк дахь протестантууд, ням гарагийг хүмүүст болон засгийн газраар хүлээн зөвшөөрүүлэхийн тулд, засгийн эрхийг гартаа авахаас илүү их хэмжээний зүйлсийг хийжээ. Энэ бол тэдний сайн чаддаг зүйл нь байсан тул үр дүн гартал тэд юу ч хийлгүй зүгээр л хүлээсэн. Ийнхүү протестантууд тэдэнтэй нэгдэн энэхүү аймшигтай зүйлийг хийснээрээ тэдний төрөлхийн бардам зант, эртний сүнсийг сэрээж, протестантуудыг ням гарагийг дагаж мөрдөхийг уриалж эхэлсэн юм. Тэдэнд сохроор атгуулсан протестантуудын эрх мэдэлд итгэлтэй байгаа учраас энэ уриалгаа үргэлжлүүлэн хийсээр байгаа. Өөрөөр хэлбэл, протестантуудын гарт байсан эрх мэдэл, хүч чадлыг одоо тэр тэднийг устгахад ашиглах болно. “*Catholic Mirror*” (Америк дахь Кардинал ба Католик сүм гэсэн үг) үүнийг л хүлээж байсныг харуулахын тулд энэ ухуулах хуудасны 21-р нүүрт бичсэнээс өөр нотлох баримт хэрэгтэй юу? Нийтлэлийг эхнээс нь эргүүлээд тэр хуудсыг дахин нэг харна уу. 1874 онд гарсан Нью-Йорк Херальд сэтгүүлээс авсан эшлэлийг бас үзнэ үү.

Методист бишопуудын мэдэгдэл яг өнөөгийн энэ цаг үеийг хэлж байгаа нь тодорхой харуулж байгаа бус уу? Үүнээс ч илүүтэйгээр протестантууд маш их нуугдмал зүйлсийг олж, тэднийг гайхшруулж, төөрөгдүүлэх зорилгоор ашиглах болно.

Энэ бол Католик Сүм ба Протестант сүмийн хоорондын маргаан юм. Ийм байдлаар бид зөвхөн *Католик толин тусгал* сэтгүүлийн нийтлэлээс эш татдаг. Маргаантай асуудал нь протестантууд үүнийг өөрсдийн давуу тал гэж үзэж, андуурдагт байгаа юм. Маргааныг Католик сүм эхлүүлсэн юм. Шийдвэр нь бидэнд биш, харин ням гарагийг сахьдаг протестантуудад хамаатай. “Энэ бол бидний сүйрэл биш” гэж бид үнэхээр хэлж чадна.

Хэрэв тэд хариу барихгүй бол тэр эмэгтэй тэдний чимээгүй байдлыг зөвтгөж, тэр үүнийгээ тэдний эсрэг ашиглах болно. Хэрэв тэд хариу баривал, тэр эмэгтэй тэдний хэлсэн үгсийн хүчийг ашиглах болно. Тиймээс протестантуудын хариу барьсан эсэх нь түүний хувьд хамаагүй бөгөөд яасан ч түүнд адилхан юм. Тэр тэдэнд хэрхэн хандаж байгаа, мөн

цаашид тэдэнтэй хэрхэн харьцахийг уриалж байгаа нь нийтлэлийн сүүлчийн догол мөрөн дэх тулгарсан бэрхшээлээс тодорхой харагдаж байна.

Протестантуудад одоо ганцхан найдвар үлджээ. Юу вэ гэвэл “зөвхөн бичээсийн үг”, “Библи болон Библи дангаараа”-г ашиглан Ариун өдрийн талаарх тэдний байр суурийг бүрэн дүүрэн авч үзэх явдал юм. Тиймд Бурханаас өөр эрх мэдлийг хүлээн зөвшөөрөхгүйгээр, Түүнээс өөр зүйлс түшиглэхгүйгээр (Ег/гар 20:12, 20), Түүний үгэнд дуулгавартай байж, Түүний хамгаалалтаар өөрийгөө бүрхүүлж, Ром болон түүний бүх холбоотнуудын эсрэг хийх тулаанд бэлтгэн, ялалт байгуулан, ялалтаа Бурханы босоо ятгаар үүрд тэмдэглэн, тэнгисийн эрэг дээр зогсох болно(Илчлэлт 18, 15: 2-4).

Протестантууд өөрсдийгөө аврах боломж одоо хүртэл тэдэнд бий. Харин тэд үүнийг хийх болов уу? Тэд өөрсдийн протестант үзэл дээрээ тууштай зогсох уу? Эсвэл тэд өөрсдийгөө протестант гэж зарласан хэрнээ католик сүмийн талд зогсож, католик сүмээр доромжлуулан, католик сүмийн үгээр байн "өөрсөдтэйгөө зөрчилдөж, сүйрлийн газар оршсоор" байх уу? Тэд зөвхөн бичээсийн үгийг даган, зөвхөн бичээсийг өөрсдийн цорын ганц эрх мэдэлтэй, үнэний жишиг болгон авах уу? Эсвэл тэд католик сүмийг дагаж, түүний эрхэнд орон тэдний тэмдгийг зүүн "өөрсөдтэйгөө зөрчилдөж, сүйрлийн газар оршин" тэдний зан үйлийг дагасаар байх уу? Тэд Библийн дагуу долоо дахь өдөр болох Ариун өдрийг сахих уу? Эсвэл католик сүмийн уламжлалын дагуу ням гарагийг сахисаар байх уу?

Эрхэм уншигч та алийг нь дагах вэ?

Хавсралт II

Энэхүү хэвлэлийн анхны дугаарыг хэвлэснээс хойш буюу 1893 оны 12-р сарын 23-ны өдөр *Католик толин тусгалд* нийтлэгдсэн нийтлэлд дараахь зүйлийг оруулсан болно.

“Эдгээр редакцын нийтлэлүүд маш их эрэлттэй байсан бөгөөд Олон улсын шашны эрх чөлөөний нийгэмлэгээс Чикаго хотод хэвлүүлсэн "Ромын сорилт" гэсэн гарчигтай дахин хэвлэлт: “Протестантууд яагаад ням гарагийг сахидаг вэ?” гэсэн гарчигтай хэвлэгдсэн юм. Мөн Чикаго, Нью-Йорк, Калифорни, Теннесси, Лондон, Австрали, Австрали, Кейптаун, Африк, Канадын Онтарио хотуудад худалдаанд гаргахаар санал болгон, байнгын эрэлт үүсэж, хамт Толин тусгалуудыг тэдэнд байнгын хүргэхээр тохиролцон, улмаар эдгээр хотуудын хэрэгцээг хангахаар болов.

“Энэ нийтлэлийн агуулга нь протестант үзлийн зан үйл болон онолын хооронд буй хамгийн тод харшилддаг зөрчилдөөнүүдийн нэг болох, ямар ч оновчтой шийдэлд үл хүрэх, Бямба гарагийг "Ариун өдөр" биш хэмээн үзэн, бичээсийн үгсийг үл ойшоож, онолоосоо татгалзан, олон нийт, дэлхийн өмнө худал ухуулгыг хийн, зааварлагч болох библийн үгсийг гуйвуулж, өөрсдийн системийг тогтоон гурван зуун хагасын турш ням гарагт мөргөлөө хийсэн католик сүмийнхэн болон зөвхөн Библи гэсэн үзэл баримтлалыг урьдаа барьдаг цор ганц үнэнийг хүлээн авсан төлөөлөгч нарын маргааны талаар юм.”

“Уншигчид маань манай нийтлэлийг дахин хэвлэх нь олон улсын шашны эрх чөлөөний нийгэмлэгээс нэмж оруулсан хавсралт хийхээс илүү сонирхохгүй гэдгийг бид мэдэрсэн юм. Хавсралттай танилцаад бидний маргаанд хариулт байхгүй гэдгийг ойлгох болно. Гурван зуун хагасын турш ноёрхон суусан католик сүмийнхний дарангуйллаас гарах талаар гэдгийг харж болно. Мөн “Хавсралт”-ын зохиолчийн тодорхой санал болгосны дагуу сайн санааны үүднээс Библийг цорын ганц зааварлагчаа болгож, өөрсдийнхөө зарчмын эсрэг хүмүүс байхаа болин, Эхлэлээс Илчлэлт хүртэл Библид заасан өдөр болох Бямба гарагт мөргөлөө хийдэг болгох эхлэлийг тавьж, католик сүмийн үзэл баримтлалтай зөрчилдөн, хохирогч байхаа больж, өөрийгөө хуурах хууран мэхлэлтээ зогсоон, хамтдаа Христийн дэлхий дээрх хаант улсын иргэд болцгооё хэмээжээ.

“Энэ товхимолд агуулагдаж буй аргументууд нь Бурханы үг дээр баттай үндэслэсэн бөгөөд үүнийг уншсанаар зааварлагч болох Библийнхээ эсрэг зогсон, буруу бүх сургаалаа тууштайгаар хүлээн зөвшөөрдөг, Ням гарагийг сахихыг тушаасан Католик сүмийн уламжлалыг орхих хүсэлгүй хүмүүст Библийг гартаа барьж, сайтар судалж үзсэнийхээ дараа ням гарагийг сахих ташаа ойлголтоо орхиж, Библийн тушаасан Бямба гарагт мөргөлөө хийхээс өөр ямар ч эргэлзээгүй болох зүйлсийг хэлдэг. Мөн энэ олон шалтгаанууд болон эрүүл дүн шинжилгээн дээр үндэслэн харвал, эдгээр хоёр талын аль нэгийг хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй юм. Протестантизм буюу Бямба гарагийг ариунаар сахих, эсвэл Католик сүм буюу ням гарагийг сахих. Алгасах боломжгүй.”